

## УЛС ТӨР, ҮЗЭЛ СУРТАЛ

М. И. Сладковский

**«НЭГДМЭЛ ХЯТАД ҮНДЭСТНИЙ» ТУХАЙ  
ИХ ХЯТАДЫН НОМЛОЛ\*****1. Их хятадын жанжлах үзэл**

Их хятадын жанжлах үзэл нь БНХАУ-ын маоист удирдлагын гадаад дотоод улс төрийн бодлогын зорилт болон зорилгыг тодорхойлж байна. Хятадын эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хоцрогдол нь түүнийг ойрын 10 жилд аж үйлдвэрийн хөгжингүй орнуудтай энх тайвнаар уралдаж дэлхийн тэргүүний орнуудын тоонд багтах боломж өгөхгүйг маоист удирдлага ойлгоод, өөрийн зорилгод дайны замаар хүрэх, тэгэхдээ юуны өмнө дэлхийн зонхилгч гүрнүүдийн хооронд мөргөлдөөн өдөөн гаргах, олон улсын нийт хурцадмал байдлыг даамжруулахыг зорьж байна. Маоист удирдлага цаг хожиж, зэвсгийн нэн шинэ төрлүүдийг үйлдвэрлэж чадахуйц орчин үеийн цэргийн аж үйлдвэртэй хүчирхэг цэрэгжсэн гүрэн байгуулах, нөгөө талаар хятадын ард түмнийг их хятадын түрэмгийлэл болон дайнд үзэл суртлын талаар бэлтгэх санаа агуулж байна. Сүүлийн үед дайны хэнээрхлийг гааруулж их хятадын фанатизмыг дэвэргэх зорилгоор улс төрийн шуугиантай олон хөдөлгөөн өрнүүлсний дотроос бүх дэлхийн түүхийг дахин хянаж үзэн (бүр тодруулбал гуйвуулж) хятад үндэстнийг зөвхөн одоогийн хятадын нутагт төдийгүй, хөрш орнуудад оршин сууж буй ард түмнүүдийг нэгтгэсэн «үүрд нэгдмэл» байсан мэтээр өргөмжилж байгаа хөдөлгөөнийг онцлон авч үзвэл зохино.

Маоист түүхчид хятад үндэстний үүрдийн нэгдлийг үндэслэлтэй болгохын тулд ард түмнүүдийн оршин тогтнох нийгэм-түүхийн нөхцөл, нийгмийн ангийн ялгарлыг өөрийн «задлан шинжилгээнээс» санаатайгаар хассаар байна. Маогийнхан үндэстэн бүрэлдэхийн тодорхойлогч шалгуур нь этногенез мөн гэдэг боловч түүнийг ичгүүр сонжуургүй гуйвуулан, нэг угсаатны бүлэгт (хан, уйгур г.м.) янз бүрийн арьстныг хамааруулж байна.

**2. Үндэстний тухай марксизм- ленинизмд харш маогийнхны үзэл**

Бээжингийн удирдагчид үндэстэн бүрэлдэх тухай шинжлэх ухааны үндэс, нотолгоогүй маоист «онолыг» гуйвуулж санаагаараа зохиосон зүйлээр халхавчлан Мао Зэдүнгийн баримтлалыг марксист болгон харуулахыг оролдож байна. Тэд нийгмийн хөгжлийн түүхийг санаатайгаар гажуудуулан үндэстний мөн чанарыг шинжлэх ухааны эсрэгээр тайлбарлан үндэстний тухай ойлголтыг хүмүүсийн нийтлэгийн үлэмж эртний хэлбэр болох овог, аймаг, ястантай адилтгаж байна.

Марксизм үндэстнийг хүмүүсийн түүхэн нийтлэг гэж тодорхойлдог бөгөөд түүний мөн чанар онцлог нь нийгэм ба угсаатны объектив субъектив хүчин зүйлийн нэгдлээр илэрдэг. К. Маркс, Ф. Энгельс нар үндэстний нийтлэгийн түүхэн шилжилтийн шинж чанарыг онцлон тэмдэглэхдээ

\*1979 оны 5-р сард Улаанбаатарт «Маоизм ба үндэстний асуудал» сэдаээр хийсэн олон улсын эрдэм шинжилгээний симпозиумд тавьсан илтгэл.

нийгмийн хөгжлийн үндэстний хэлбэрийн үүслийг капитализмын батжилтай холбосон билээ.

Тэд капиталист байгууллын нөхцөлд нийгмийн ангийн ялгарал пролетарийн интернационализмыг илэрхийлэгч ажилчин анги, хөрөнгөтний үндсэрхэх үзлийг агуулагч хөрөнгөтөн<sup>1</sup> анги хоёрын хоорондын зөрчлийг төрүүлдэг эдийн засгийн хүчин зүйлүүд нь үндэстэн бүрэлдэн тогтноход шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг.

Шинжлэх ухааны социализмыг үндэслэгч Маркс Энгельс нар нийгмийн хөгжлийн түүхэнд нийгмийн тодорхой хэлбэршлийн дагуу овог, аймаг, угсаатны түүхэн нийтлэг байдаг гэж заасан билээ. Тухайлбал анхны хүй нэгдлийн нийгэмд овог-аймгийн нийтлэг, боол эзэмшлийн ба феодалын нийгэмд угсаатны нийтлэг тус тус бий болдог байна. Ленин Маркс Энгельс нарын үзлийг хөгжүүлэн капитализмын үед үндэстэн бүрэлдэн тогтох түүхэн зүй тогтоолыг бүрэн төгс үндэслэсэн юм. «Үндэстнүүд бол нийгмийн хөгжлийн хөрөнгөтний үеийн зайлшгүй бүтээгдэхүүн, зайлшгүй хэлбэр мөн»<sup>2</sup>. В. И. Ленин үндэстний өөрийн нь мөн чанарыг шинжлэх ухааны үүднээс задлан шинжилж түүний нийгмийн ба угсаатны харьцааг зөв тогтоосонд Лениний онцгой гавьяа оршино. Тэр, оросын народникууд (Н. Михайловский г, м.) үндэстний мөн чанарыг зөвхөн угсаатны нийтлэгт хамааруулан, түүнийг биеэ даасан, нийгмийн үйл явцаас ангид үүрэг гүйцэтгэдэг болгох гэж оролдсоны бүх бурууг батлан харуулсан юм. Ленин үндэстнүүдийн хооронд хэлхээ холбоо тогтоох нь нийгмийн хэлхээ холбоо тогтоохоос өөр байж болохгүй. Тийм хэлхээ холбоог хөгжүүлэх, түүний мөн чанарыг тодорхойлон тогтоогч гол зүйл нь эдийн засгийн хүчин зүйлүүд юм гэж онцлон тэмдэглэсэн байдаг.<sup>3</sup> Үндэстний тухай марксист онолыг хөгжүүлэхэд Лениний байгуулсан том гавьяа бол үндэстний нийтлэгийн гол шинжүүдийг тодорхойлсон явдал юм. Ленин зөвхөн үндэстний мөн чанарын шинжүүдийг тоочоод зогсоогүй, харин тэдгээрийн агуулга, харилцаа холбогдлыг илрүүлэхэд голлон анхаарсан байдаг.

В. И. Ленин хэлний үүргийг угсаатны хүчин зүйл гэж өндөр үнэлэхийн зэрэгцээгээр үндэстэн бүрэлдэн тогтож хөгжихөд хэлний гүйцэтгэх нийгмийн үүргийн ач тусыг тайлбарлахыг их анхаарсан байдаг<sup>4</sup>. В. И. Ленин үндэстэн үүсч, хөгжихөд газар нутгийн хүчин зүйл ямар үүрэг гүйцэтгэдгийг шинжлэх ухааны үүднээс тайлбарласан юм. Бауэр үндэстнийг онцгой ухагдахуун болгох гэж байсныг тэр шоолсон байдаг. В. И. Ленин үндэстнийг тодорхойлогч үндсэн шинжүүдийг задлан шинжилж газар нутгийн нийтлэг бол эдийн засгийн хүчин зүйлийг тодорхойлогч үйлдлийн чухал нөхцөл гэж үзсэн юм. Эдийн засгийн хэлхээ холбоо ихсэх, дотоод зах зээл үүсэх нь үндэстнийг бататгадаг гэж тэр тэмдэглэсэн байдаг. Бусад бүх шинж нь чухамдаа дагалдах чанартай буюу үгүйдээ л эдийн засгийн амьдралын нийтлэгт захирагдаж, хүчин зүйлүүдийн энэ нийтлэгийн нөхцөл болж байдаг байна. Ингэхээр үндэстэн гэдэг бол нийгэм капитализмд шилжихэд хэл, нутаг дэвсгэрийн нийтлэг, соёл, ухамсар болон сэтгэл зүйн онцлогууд хослож, эдийн засгийн амьдралын нийтлэгийн бааз дээр бүрэлдсэн нийгмийн хөгжлийн хэлбэр болох хүмүүсийн тогтвортой түүхэн нийтлэг мөн.

В. И. Ленин капитализмын нөхцөлд тааруулж дүрслэн хэлэхдээ: үндэстэн бүрт хоёр үндэстэн байна гэсэн юм.<sup>5</sup> Лениний энэ үндэслэл капи-

<sup>1</sup> К. Маркс и Ф. Энгельс. Соч. т. 2, 590-р тал; т. 4, 375-р тал: т. 16, 10—11-р тал, т 21, 374-р тал.

<sup>2</sup>В. И. Ленин. Зохиолууд, б. 21, 60-р тал.

<sup>3</sup>Мөн зохиол, б. I. 145-р тал

<sup>4</sup>Мөн зохиол. б. 20, 54-р тал.

<sup>5</sup>В. И. Ленин. Зохиолууд. б. 20, 17-р тал.

талист үндэстний мөн чанарыг ойлгоход арга зүйн чухал ач холбогдолтой юм. Лениний үндэстний «хоёр нэгдэл» нь капиталист үндэстний уг чанарын бүх учрыг танин мэдэх боломж өгдөг. В. И. Лениний ойлголтоор «хоёр үндэстэн» гэдэг бол нэг (гэхдээ нэгдмэл биш) үндэстний нийтлэгийн эсрэг тэсрэг хоёр нийгэм-ангийн тал юм. Тэгэхдээ Лениний энэ үндэслэл капитализмын үед үндэстний нэгдэл харьцангуй байдгийг харгалзсан байна.

Социализмын үед бүх хөдөлмөрчдийн ангийн ба үндэстний эрх ашиг, коммунизм, социализм байгуулах сонирхол давхцдаг учраас үндэстний нэгдлийн батжил хэмжээлшгүй өсдөг.

Социалист нийгэмд үндэстнүүдийн эдийн засгийн хөгжил жигдэрч тэдгээрийн соёл өндөр хөгжилд хүрдэг.

Үндэстнүүдийн бүрэн тэгш эрхийн тухай Лениний зарчмын үндсэн дээр социалист нийгэмд социалист интернационализмын үзэл санаа батжиж, үндэстнүүд хоорондоо ойртож, шинэ дээд нийтлэг болох социалист ард түмний нийтлэг үүсч тогтдог.

Л. И. Брежнев ЗХУ-ын шинэ үндсэн хуулийн төслийг хэлэлцэхэд хэлсэн үгэндээ: ЗХУ-ын нутагт оршдог бүх үндэстний хөгжилтийг нарийвчлан шинжилж эдийн засаг, оюуны амьдралын хөгжилтөд гарсан амжилтыг дурдан түүний үр дүнд зөвлөлтийн үндэстнүүд ойртон нягтарч зөвлөлтийн ард түмэн гэдэг шинэ нийтлэг бий болсныг харуулсан билээ. Арьсны өнгөөр адилшаах эсэх нь үндэстний нийтлэгээс ялгаатай хүн судлалын ухагдахуун юм. Түүний үүсэл нь хүн ба хүний нийгэм үүссэний эхний шатанд холбогдоно. Арьсны ялгаа бол хүний бие бялдрын хэв шинжийн ялгаа юм. Түүнчлэн үйлдвэрлэх хүчний хөгжлийн туйлын доод шатанд, бие биенээсээ тусгаарлагдмал хэсэг бүлгээрээ олон мянган жилийн турш амьдарч байсан анхны хүй нэгдлийн хүмүүсийн амьдралын газар зүй, цаг уурын нөхцлийн эрс тэс ялгааны үр дүн мөн. Ийм нөхцөлд бий болсон арьсны шинж тэмдэг-үс, арьсны өнгө, толгойн хэлбэр, хамар зэрэг нь байгальд зохицсон хамгаалалтын чанартай юм. Гэвч цаашид (нийгмийн тодорхой шалтгаануудын эрхээр) хүмүүс ийш тийш нүүн суурьшсан нь янз бүрийн арьстнууд холилдоход хүргэж олон өөр янзын арьстан үүсгэхэд хүргэжээ. Хүн судлаачид одоо үед хүн төрөлхтний арьстны тоог тогтоох талаар санал зөрж байгаа боловч тэдгээрийг негржүү (хар), европжуу (цагаан), монголжуу (шар) арьстан гэж гурван том бүлэг болгон ангилахыг нийтээр хүлээн зөвшөөрч байгаа билээ.

### **3. Маогийнхны их хятадын жанжлах үзлийн түүхэн «үндэслэл»**

Сүүлийн жилүүдэд БНХАУ-д төрөл бүрийн ном зохиол, түүний дотор сурах бичиг, газрын зураг мэтийг үй түмээр хэвлэн нийтэлж улс төрийн сүржин кампани, «онолын» бага хурлуудтай хослуулж байгаа нь хятадын ард түмэнд их хятадыг бишрэх үзэл төрүүлж, БНХАУ-ын маоист удирдлагын дайнч, жанжлагч бодлогыг «үндэслэлтэй болгох» ганц зорилгыг мөрдлөг болгож байна. Чухамхүү үүнд л БНХАУ-д сурталдаж байгаа «нэгдмэл хятад үндэстэн» гэдэг номлол үйлчилж байна. «Хятад үндэстэн» (чжунхуа миньцзу) гэдэг нэр томъёо хятадын утга зохиолд харьцангуй саяхан манай зууны дөчөөд оны үед гарч ирсэн юм. 1948 онд хэвлэгдсэн цыхай (үгсийн далай) гэдэг толь бичигт «чжунхуа миньцзу» гэдэг нэр томъёо байхгүй. Цыхай толь бичгийн «Дундат Иргэн Улс» (Чжун- хуа миньго) гэдэг өгүүлэлд хятадад оршдог хан (хятад), манж, монгол, хотон (лалын шашинт) төвд, мяо гэх зэрэг үндэстнүүдийг тоочсон байдаг. Үүнээс үзэхэд «Чжунхуа миньцзу» гэдэг нэр томъёо хятад хэлний үгийн санд «Чжуан Хуа Миньго» (Дундат Иргэн Улсыг)-г тунхагласнаас хойш орсон бололтой агаад бүгд найрамдах улсын төр гэсэн үгтэй ойролцоо

утгатай хэрэглэж байжээ. Энэ нэр томъёоны чухамхүү учир утгыг Чан Кайши тодруулан тайлбарласан байдаг. Хятадад дөчөөд онд сүүлийн жилүүдэд Тайваньд олон удаа дахин хэвлэгдсэн «Хятадын хувь заяа» гэдэг номдоо Чан Кайши бичихдээ: «Үндэстэн бүрэлдэн тогтсон түүхийн тухайд гэвэл манай хятад үндэстэн нь олон овог холилдсоноос үүссэн юм. Энэ олон овгууд нь өөрийн гарал үүслийн хувьд гэвэл нэг арьстнаас салбарлан гарсан агаад нэг системд багтдаг Памирын өндөрлөгөөс зүүн этгээд Хатан гол (Хуанхэ), Хуайхэ, Хөх мөрөн (Чанцзян), Хар мөрөн (Хэйлунцзян), Чжуцзян голуудын сав газраар тархсан байдаг. Тэд газар зүйн байдлаасаа шалтгаалсан янз янзын соёлтой. Соёлын ялгааны эрхээр янз бүрийн овгийн нэртэй байдаг. Гэвч сүүлийн 5 мянган жилд тэдгээрийн хооронд олон хэлхээ холбоо үүсч, байнга шилжин суурьшиж байсны эцэст өөр хоорондоо холилдон нэг үндэстэн болон хувирчээ. Гэвч тэднийг нийлж нэгтгэхийн хөдөлгөгч хүч нь үл дагагчдыг дарангуйлан нэгтгэх аргууд, зэвсгийн хүч биш харин соёл байлаа»<sup>1</sup>.

Чан Кайши марксист биш гэдэг нь хэн бүхэнд илэрхий, тэр хэзээ ч өөрийгөө тийм болгох гээгүй билээ. Тэр их хятадын үндсэрхэг үзэл, арьсны үзэл баримталж байсан бөгөөд өөрөө түүнийгээ хангалттай ил тод өгүүлсэн байдаг. Маоист түүхчид өөрсдийгөө өөрөөр харуулахыг хичээж байна. Тэд өөрсдийн их хятадын үндсэрхэг онолыг үндэслэгчдээ ичгүүртэй далдалж мөн л «тууштай марксист»-ын жанч нөмөрч байна. Гэтэл хятад үндэстний үүрдийн бат нягтрал, нэгдэл гэгчийн онолд марксизмаас юу ч байхгүй, түүний үндэсгүй нь зөвхөн үндэстэн, овгийн нийтлэг арьстны тухай шинжлэх ухааны ойлголтыг самууруулсан төдийд биш харин одоогийн хятадын нутаг дээр оршиж байгаа ард түмнүүдийн өөрсдийнх нь бодит түүхийг бүдүүлгээр гуйвуулж байгаад оршиж буй нь юманд бодитой ханддаг хэн бүхэнд бүрэн тодорхой юм.

Гэтэл Азид овог-аймгийн нийтлэг, ястан үндэстэн улсууд, тухайлбал хятадад үүссэн түүх нь, нийгмийн хөгжлийн тухай марксист сургаалын шинжлэх ухааны үндэстэйг үнэн зөв болохыг гялалзтал баталж байна. Эдийн засгийн үндэс нь газар тариалан, түүнээс салбарлан гарсан гар урлал байсан Хятад орон, аж ахуйн үндэс нь мал аж ахуй бүхий хөрш нүүдэлчин ард түмэн хоёрын хоорондын харилцаа нь тэдгээрийн угсаатны ба арьсны адил буюу ялгаагаар биш, харин материаллаг үйлдвэрийн арга, материаллаг хэрэгцээгээр тодорхойлогдож байв. Хятад ба одоогийн хятадын нутагт оршиж байгаа урьд тусгаар тогтносон улс байсан ард түмнүүдийн хоорондын харилцаа нь ямагт нөхөрсөг байсан агаад тэдгээрийн «нэгдэх арга нь байлдан дагуулал биш ивээн тэтгэх явдал байсан» мэтээр Чан Кайши болон орчин үеийн маоист түүхчид нотолж байгаа нь үндэсгүй бөгөөд түүхэн баримттай харшилж байна. Цинь Шихуаны (м. э. ө. 246—210 он) удирдлагаар хятадад төвлөрсөн улс байгуулагдахдаа Хөх мөрний чанад нутагт Хятадын зүүн өмнөд хэсэгт «Минь юэ», өмнөд хэсэгт Бай юэ, баруун өмнөд хэсэгт Дянь гэх зэрэг биеэ даасан улсууд байсан хятад бус ард түмнүүдийг цус урсган хайр найргүй устгасан түүхтэй билээ. Засаг захиргааны 36 хувиараас бүрдсэн төрийн захиргааны систем тогтоосон, Цинь Шихуан хойт, баруун хойт талаараа цагаан хэрмээр эмжээрлэн улсын хилээ нилээд тодорхой тогтоосон билээ. Тэр цагаас эхлэн XX зууны дунд үе хүртэл хятадын түүхийн бүх бүтээлүүдэд хятадыг «Гадаад», «Дотоод» гэж хуваасан байдаг нь «хэрмийн гаднах» ард түмнүүдийн үндэстний ялгаа, онцгойдуу байдлыг харгалзсан нь болой. Хятадын дараагийн түүх бол хэрмийн гаднах ард түмэн хийгээд хятад нь олон зууны турш хоорондоо тэмцэлдэж байсан бөгөөд олонхидоо

<sup>1</sup>Чан Кайши. Чжунго чжи минь юнь (Хятадын хуяь заяа), Тайбэй. 1976. 2-р тал.

хятадын ялагдлаар төгсч түүний хаан ширээ хаант төрийн байгууллын сүүлчийн мянган жилийн 700-гаад нь харийн гарт байжээ.

Хатуу ширүүн дайнууд нь их төлөв хятадыг доромж үзсэн гэрээнүүдээр төгсдөг байв. Хятадын армийн ялагдсанаас болж Хятад орон донсолж байсан баримтууд түүхэнд нилээд байдаг. Жишээ нь: Сүн улсын үед буюу XII зуунд хойт хятад руу Зүрчид (манж-түнгүүс)-ийн «Алтан» улсын цэрэг довтолж цохиод Алтан улсын эзэн хаан Агудад Сүн улсын эзэн хаан Гао Цзу дараахь үүргийг авч найрамдлын (Шаосинийн) гэрээ байгуулсан байдаг. «Гао миний бие мэдэгдэх нь: Одоогоос эхлэн (манай хоёр улсын) хил Хуайшуй голоор тогтоогдоно. Танчжоу, Дэнчжоу...гээс баруун тийш орших нутаг танай улсад шилжинэ. Соёрхох ахул таны түшмэл болж үнэнч байхаа тангараглана. Миний бие эзний түмэн өлзий бадарсан сайн өдөр хийгээд шинэлэх өдрийг тохиолдуулан элч зарж амгаланг айлтгаж, бэлэг хүргэх, жил бүр 2 бум 5 түмэн лан мөнгө, 2 бум 5 гүмэн толгой торгоор алба барьж байхыг ямагт андгайлна»<sup>1</sup> гэсэн байдаг. Зүрчид нар XII зуунд хятадад довтолсныг хятадын түүхийн шинжлэх ухаан түрэмгий дайн гэж үздэг бөгөөд энэ дайнд хятадын цэргийн жанжин нарын нэг Юэ Фэй баатарлаг тулалдсаныг хятадын ард түмэн одоо болтол үндэсний баатар<sup>2</sup> гэж алдаршуулдаг билээ. Энэ бүх түүхэн үнэн баримт нь хятад ба хятад бус ард түмний хооронд үүрдийн «ах дүүгийн зохицол» байсныг биш харин тэдний харилцаан дахь дайснагнал, олон зуун жилийн тэмцэл байсныг гэрчилж байна. Мао Зэдүний өгүүлүүдэд ч «олон үндэстний хятад улсын ард түмнүүд мянган жилийн туршид...харийн дарлалын эсрэг тэмцэж байсан юм»<sup>3</sup> гэж хүлээн зөвшөөрсөн байдаг.

Одоогийн маоист түүхчид шинжлэх ухаанд, ард түмний дотор тогтсон үнэлэлтээс илэрхий татгалзаж, Мао Зэдүнтэй санал нийлэхгүй байгаагаа албан ёсоор мэдэгдэж зүрхлэхгүй байна. Иймээс тэд түүхэн баримт, үйл явдлын үнэн утга санааг өөрөөр урвуулан тайлбарлах ердийн заль мэхээ хэрэглэж байна. Хэдэн мянган жилийн турш хятад, хятад бус ард түмнүүд хийгээд Азийн улсуудын хооронд болж байсан дайныг, тэд нэгдмэл хятадын ард түмний дотоодын дайн гэж зарлаж байна.

1979 оны 2-р сард хятадын «Гуанмин жибао» сонин Мао Зэдүний «харийн дарлалын эсрэг» мянган жилийн тэмцлийн тухай дурдсаныг тайлбарлахдаа: Энэ ойлголт нь капиталист, империалист гүрнүүдээс хятадын эсрэг хийсэн түрэмгийллийн хувьд бүрэн зөв боловч «үндэстний дотоодын дайн»-д огт тохирохгүй гэсэн билээ. Зүрчид бол хятадын үндэстний нэг байсан тул түүнээс хятадын Сүн улсын эсрэг хийсэн түрэмгийлэл нь «үндэстнүүдийн дотоодын зөрчил буюу тэмцлийн» жишээ юм. Тэгэхдээ Зүрчидүүд шударга биш «дотоодын үндэстний дайн хийсэн» гэж үзвэл зохино хэмээн өгүүлэлд дурджээ.

Ийнхүү илт гуйвуулсан тайлбарлалыг зөвхөн «Гуанмин жибао» сонины санал гэж болохгүй. 1978 оны 3-р сард Хуа Гофэн, Дэн Сяопин нар оролцож үг хэлсэн бага хурлын чиглэлийг тус сонин удирдамж болгосон нь дамжиггүй. Хятадын эзэн хаадаас эртний болон шинэ түүхийн үед явуулж байсан дайны булаан эзлэгч, харгис шинж чанарыг түүх хангалттай илчилж байна. Хятадын түүхч Фань Вэньлань Чин улс, их төлөв уйгурууд өөрийн суудаг «хэрмийн гаднах» дорнод Түрэгстан (хятадууд түүнийг «шинэ хязгаар» буюу Синьцзян муж болгон өөрчлөн нэрлэсэн)- ыг эзлэн түүхийг бичихдээ, энэ булаан эзлэгч дайн хэтэрхий их цус урс-

<sup>1</sup>«Очерки история Китая» (Хятадын түүхийн найруулал) (Эртнээс «Хар тамхины дайн» хүртэл), Редактор Шан Юэ (Хятадаас орчуулсан) М., 1959 т.г 334-р тал

<sup>2</sup>Мөн тэнд, 327—333-р тал.

<sup>3</sup>Мао Зэдүн. Избранные произведения т. II. Пекин. 1969, 383-р тал (на русском языке)

гаснаар барахгүй бүрэлгэн сүйтгэгч шинж чанартай байсныг тэмдэглэсэн байдаг.

Маоист түүх бичигчид Чин улсын байлдан дагуулагчид Дорнод Түркстаны үндсэн хүн амыг хүйс тэмтрэн устгаж байсан нууж болшгүй аймшигт гэмт хэргийн ямар нэгэн онцгой «тайлбарлалтыг» хараахан «боловсруулаагүй» байгаа бололтой. Тэд өөрсдийн тогтоосон бүдүүвчид багтахгүй, эсвэл түүнтэй зөрчилдөж байгаа түүхэн бүх баримтын тухай ярихгүй байна.

Урьд одоогийн харгис эрх баригчдын уламжлалт бодлого нь одоо хятадад оршин сууж байгаа ард түмнүүдийн «үүрдийн нэгдлийг» нотлохгүй байна. Харин ямар ширүүн тэмцэлд хятад улс үүсэн тогтсон, үндэстний тэгш бус байдал, дарлал мөлжлөг хятадад ямар хүнд өв үлдээснийг түүх хангалттай, үнэмшихүйц харуулж байна. Сурталдаж буй «хятад үндэстний нэгдэл» гэгч онол нь маоист удирдлагад зөвхөн хятад хүмүүсийн ноёрхлыг бэхжүүлэхэд нь хэрэгтэй юм. Энэ онол хятад биш ард түмний биеэ даасан байдал, үндэстний түүхийг хасч, тусгаар тогтнол, биеэ даасан байдал, хэл, уламжлалаа хадгалахын төлөө тэдний хийсэн олон зуун жилийн тэмцлийг үгүйсгэж байна.

#### **4. «Нэгдмэл хятад үндэстэн»-ий тухай их хятадын номлолын гадаад бодлогын зорилт**

Маоист түүхчид «нэгдмэл хятад үндэстэн» гэдгээ зөвхөн одоо хятадын нутагт оршин сууж байгаа ард түмнүүдээр хязгаарласангүй. Түүнд хөрш ба алс оршдог ард түмнүүдийг нэгэн «хятад их биеэс» салбарласан «мөчир» хэмээн маоист ойлголтоор үзээд хятад бол тэдгээр ард түмний нутаг, өмчийг өвлөн авах эрхтэй үндэслэл гаргаж байна. Тэгэхдээ маоистууд эхний ээлжинд өөрсдийн томоохон улсыг байгуулж, Азийн хязгаараас давсан өргөн уудам нутаг эзэмшиж байсан тийм ард түмнүүдийг сонирхож байна.

Сүүлийн үед маоист түүх бичигчид хүннү (сюннү)-г онцгой анхаарч байна. Хүннү бол Төв Азиас Уралын хавь руу нүүдэллэдэг үндсэндээ түрэг хэлтнээс бүрэлдсэн эртний нүүдэлчин ард түмэн гэдэг дэлхийн шинжлэх ухааны тогтсон ойлголтыг сөрж маоист «түүхчид» мэдэгдэхдээ: «Сюннү» бол аль нэгэн «дайсан ард түмэн» биш харин эртний хятадын нэгэн бага үндэстэн гэж байна. Маоист түүхчид зөвхөн дэлхийн төдийгүй хятадын түүхийн шинжлэх ухаантай зөрчилдөж байгаадаа ичихгүй байна. Хятадын түүхийн утга зохиолуудад хүннү хятад руу хийж байсан бүрэлгэн сүйтгэгч довтолгооны тухай зөндөө баримт байдаг. Хятадын эзэн хаан Гаоцзу (Хан улсыг үндэслэгч, Лю Бан) хүннүтэй байлдаж хүнд ялагдаад м. э. ө. 192 онд хүннүгийн Шаньюй Маодуньтай аргагүйн эрхэнд гэрээ байгуулан найрамдаж ураг барилдаад (Модуньд хятадын гүнжийг өгсөн-М. С.) Хятад улс жил бүр торго, хөвөн, архи гэх зэрэг тансаг алба<sup>1</sup> барьдаг болсныг дурдахад хангалттай юм. Ийнхүү эмгэнэлт үйл явдлууд хятадын ард түмэнд илэрхий бөгөөд түүхийн зохиол, ардын туульс зэрэгт туссан байдаг тул түүнийг нууж болохгүй. Гэтэл маоист түүхчид үйл явдлын мөн чанарыг ичгүүргүй гуйвуулан тэдгээрийг шууд урвуу утгатай болгоод зогсохгүй, харин Хятад улс үүсэхэд өөдрөг үүрэг гүйцэтгэсэн мэтээр тайлбарлаж байна. Маоист түүхч Сяо Чжисин бичихдээ: «Хан, Тан улсуудын үед найрамдаж ураг барилдах тухай байгуулсан гэрээнүүд нь манай улсын түүхэнд янз бүрийн үндэстнүүд нөхөрлөж нягтрахад дөхөм болсон»<sup>2</sup> гэжээ.

Маоист түүхчид хятадын түүхийн сонгодог утга зохиолтой илэрхий маргахгүйгээр, урьдын судалгааны үндэстэй бүх үзлийг «дөрвөн дээрэм

<sup>1</sup> «Очерки история Китая». Под редакцией Шан Юэ. 78-р тал.

<sup>2</sup> «Гуанмин жибао» сонин. 1978. XII. 9.

чин гуйвуулсан» гэж зарлаж байна. Хань Жулин «манай орны үндэстнүүдийн түүхийг судлах ажлыг урагшлуулая!» гэдэг өгүүлэлдээ: «Тэд» буюу «дөрвийн бүлэг» манай орны хойт талд оршиж байсан эртний хүннү угсаатныг «умар зүгийн нэгэн манлай» мэтээр үзэж байсан; Түүхэн дэх үндэстний цөөнхийг «гадны дээрэмчид» гэж нэрлэсэн; тэд нөхөрлөл, харилцан нэгдэх явдал үндэс нь болж байсан манай улсын түүхэн дэх үндэстний харилцааг тасралтгүй хатуу, түрэмгий дайн байсан шигээр дүрслэж байсан; Хилийн мужуудыг эзэмших, хятад үндэстний (Чжунхуа миньцзу) эдийн засаг, соёлыг хөгжүүлэхэд үндэстний цөөнхийн оруулсан гарамгай хувийг тэд бийрний ганц зуралтаар устгасан»<sup>1</sup> гэж бичиж байв.

Хятадын үндсэрхэг түүхчид XIII—XIV зуунд оршиж байсан Монголын хүчирхэг гүрний түүхэн өвийг залгамжлахын тул Чингис хаантай «ах дүү болохыг» Гоминьданы ноёрхлын жилүүдэд хайж байлаа. Чингис хаантай «ах дүү болохыг» хятадын марксист түүхчид, хувьсгалт ардчилсан олон нийт буруушааж угтсан билээ.

Маоист түүхчид их хятадын үндсэрхэг ерөнхий чиглэлийг баримтлаж «Чжунхуа миньцзу» буюу хятад үндэстэнд багтаан тоолж байгаа ард түмнүүдийн урьд эзэмшиж байсан бүх нутгийг хятад эзэмших түүхэн эрхтэй гэж нотлохыг хичээж байна. Маоист түүхч Чин Упин мэдэгдэхдээ: «түүхийн явцад хятадын хил хязгаар нэг бус удаа өөрчлөгдөхдөө зөвхөн хятадууд оршин суудаг нутгаар хязгаарлагдаж байгаагүй. Манж, монгол, уйгур, төвд, мяо, яо, чжуан болон бусад олон үндэстнүүд хятадуудтай нэгэн адил, Чин улс тогтохоос бүр өмнө хятад үндэстний (Чжунхуа миньцзу) бүрэлдэхүүн хэсэг байсан, тэдний оршин суудаг нутаг ч хэзээнээсээ хятадын нутгийн бүрэлдэхүүн хэсэг байсан»<sup>2</sup> гэжээ.

Маоист суртал нэвтрүүлэг их хятадын жанжлах үзэл, түүний гол нь болж байгаа газар нутгийн түрэмгийллийг хятад хүний гадаад бодлогын төсөөллийн хэв хэмжээ болгон өргөмжилж байна. Энэ нь хятадын залуучуудын сургалтын бүрэлдэхүүн хэсэг болж дунд, дээд сургуулийн албан ёсны сурах бичгүүдэд орж байна. Хятад хүнд чи бол «бүх хүн төрөлхтний модны их бие» мөн тул, салбарласан бүх «мөчрийн» өсөлт чамаас хамаарна гэдэг үзэл санааг тулгаж байна. Хичээлийн гарын авлага зохиодог хэсэг түүхчдийн нэрээр дунд ба бага сургуульд үзэх «Хятадын түүх» гэдэг сурах бичгийг 1978 онд хэвлэн гаргав. Тэр сурах бичиг их хятадын үзэл санаа, хятадууд бага ард түмнүүдийг байлдан эзлэхийг үл тоомсорлох, ихэмсэг үзлээр залуучуудыг хүмүүжүүлэх эрмэлзлэлээр бүрэн нэвтэрхий юм. Сурах бичигт Тан улс БНХАУ-ын одоогийн нутгийн хилээс давсан уудам нутагтай байсныг их тодорхой бичээд, мэдээжээр Тан улсад хамаарагдаж байсан Солонгос, БНМАУ, Вьетнам, Зөвлөлтийг Дундат Азийн бүгд найрамдах улсууд цөм л «түүхийн ёсоор хятадын нутаг юм»<sup>3</sup> гэсэн дүгнэлт хийжээ. Тан улс байгуулагдахаас өмнө томхон улсууд (Баруун Түрэгийн хаант улс, Зүүн Түрэгийн хаант улс) болон нэгдэж байсан их уйгурын ард түмнийг Тангийнхныг «өөрийн багш» гэж үздэг хоцрогдмол ард түмэн байсан мэтээр дүрслэжээ.<sup>4</sup>

Сурталчилж байгаа үүрдийн «нэгдмэл хятад үндэстний» тухай номлол бол зөвхөн хүн амыг бусад ард түмнээс давуу гэдэг үзэл санаагаар хүмүүжүүлэхийн тулд зохиож байгаа их хятадын сурталын тулгуур чулуу төдийгүй, бас БНХАУ-ын маоист удирдлагын улс төрийн практик ажиллагааны «онолын үндэслэл» болж, түүний гадаад бодлогын түрэмгий чиглэлийг зөвтгөж байна. Маоизм бол марксизм-ленинизмийн дайсан болох

<sup>1</sup>Мөн сонин. 1978. IV. 7.

<sup>2</sup>«Гуанмин жибао» сонин. 1976. IV. 8.

<sup>3</sup>«Чжунго лиши» (Хятадын түүх, сурах бичиг. 133-р талд)

<sup>4</sup>Мөн тэнд. 134-р тал.

нь «нэгдмэл хятад үндэстний» тухай номлол, түүний улс төрийн практик, хятад бус ард түмэнтэй харьцах бодлого зэрэгт бүрэн илэрч байна.

Маоист түүхчид овог, аймаг, угсаатан, үндэстэн гэдэг хүмүүсийн түүхэн нийтлэгийн элдэв хэлбэр байгааг санаатай үгүйсгэж үүрдийн нэгдмэл хятад үндэстний тухай онолоороо нэгдмэл хятад төвийн үзэл, их хятадын жанжлах үзлээ бататгахыг оролдож байна.

Үндэстэн угсаатан социализмын нөхцөлд Лениний сургаалын үндсэн дээр бүх үндэстнийг улс төрийн бүрэн тэгш байдалтай болгох, социализмын туйлын зорилт болох улс төрийн ерөнхий зорилтыг хэрэгжүүлэхийн тул үндэстэн бүхнийг цэцэглүүлэхүйцээр эдийн засаг, соёлыг өрнүүлэх замаар ойртон нягтарч байна. Гэтэл маоизм хятад бус ард түмнүүдийг хүчээр уусгаж, тэдний нутгийг хятадын цэргийн суурин болгон хувиргах замаар «мөчрийг» устгаж «хятад их бие» болгохыг оролдож байна. Үндсэрхэг бодлого нь бусад ард түмнүүдийн тусгаар тогтнолын эсрэг чиглэж, их хятадын түрэмгий үзлийг илэрхийлж байна.

**М. И. Сладковский**

### «ВЕЛИКОХАНЬСКАЯ ДОКТРИНА ЕДИНОЙ КИТАЙСКОЙ НАЦИИ»

#### Р е з ю м е

Великоханьский гегемонизм определяет сущность всей внутренней политики маоистского руководства КНР, включая его политику по национальному вопросу, и поэтому не случайно особое место оно выделяет возвеличиванию китайской нации как «извечно единой», якобы объединяющей не только народы, населяющие современную территорию Китая, но и территории соседних стран.

Суть доктрины «единой китайской нации» (чжунхуа минцзу), выдвинутой в свое время Чан Кайши, заключается, прежде всего, в ее фактическом игнорировании некитайских наций и народностей, населяющих территорию Китая, а в прошлом имевших свою суверенную государственность с тем, чтобы оправдать и обосновать теорию об извечной монолитности и единстве китайской нации, что, естественно, сугубо антинаучно, так как в ней не только перепутаны научные понятия нации, родовой общности, расы и т. д., но грубо фальсифицируется и сама фактическая история народов, населяющих современную территорию Китая.

Утверждения, Чан Кайши и современных маоистских историков о том, что отношения между Китаем и народами, населяющими территорию Китая в прошлом и настоящем, якобы постоянно оставались дружественными, не имеет оснований и противоречит историческим фактам. История же в достаточной степени изобличает захватнический и жестокий характер войн, осуществлявшихся китайскими императорами во времена древней и новой истории, навязанных ими сопредельным с Китаем странам.

Пропагандируемая теория «единство китайской нации», утверждающей главенство ханьцев, включает в себя также внешнеполитические цели. Великоханьская доктрина «единая китайская нация», пишет автор, рассматривает соседние и даже дальние народы «ветвями» одного «ханьского ствола», что по маоистским представлениям, дает основание Китаю унаследовать территориальные и иные права этих народов, Этим же

объясняется тот факт, почему в последнее время маоистские историографы особое внимание уделяют гуннам («сюнну») и Чингизхану, чьи государства в прошлом владели обширными территориями, далеко выходящих за пределы Азии.

Великоханьский гегемонизм и его сердцевина-это территориальный экспансионизм, утверждает автор, а доктрина извечности «единой китайской нации» является не только краеугольным камнем великоханьской идеологии, но в то же время она служит «теоретическим обоснованием» политической практики маоистского руководства КНР, оправданием его внешнеполитического экспансионистского курса.

Враждебность маоизма марксизму-ленинизму в полной мере раскрывается в доктрине «единой китайской нации», в его политической практике и политике по отношению к неханьским народностям, в частности, в политике насильственной ассимиляции последних путем превращения их территорий в военные поселения ханьцев-уничтожением «ветвей» на «ханьском стволе». Националистическая политика маоистов направлена и против независимости других народов.